



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

# **ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ**

**Дугаар 2020/06**

**Улаанбаатар хот  
2020 он**

## ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Аж үйлдвэр	2
2. Мал аж ахуй	4
3. Газар тариалан	6

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

## 1.АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр 6.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (22.5%) их наяд төгрөгөөр буурлаа.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2020\* оны эхний 6 сард



Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.6 (26.9%) их наяд төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 279.6 (15.7%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны 6 дугаар сард 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 176.1 (15.1%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 144.4 (17.7%) тэрбум төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 40.7 (15.7%) тэрбум төгрөгөөр өссөн.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 2020 оны эхний хагас жилд алт болон төмрийн хүдэр олборлолт өмнөх оны мөн үеэс 15.9-42.4 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт спирт, гурил, ус, ундаа, жүүс, шингэн сүү зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7.6-14.2 хувиар тус тус өссөн байна. Мөн нүүрсэн шахмал түлш болон амны хаалтны үйлдвэрлэл 2020 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 3.0-21.0 дахин өссөн байна.

**Боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл,  
дэд салбараар**

Дэд салбар	2019		2020*		2020* I-VI
	VI	I-VI	VI	I-VI	2019 I-VI
	сая төгрөг				хувь
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>350 100.9</b>	<b>1 780 585.3</b>	<b>300 421.8</b>	<b>1 500 974.2</b>	<b>84.3</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	131 284.8	752 134.2	123 171.3	742 723.5	98.7
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	19 876.6	102 689.0	20 936.9	80 835.5	78.7
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	16 385.8	108 882.5	18 110.4	114 614.8	105.3
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл	16 330.4	98 155.2	15 565.5	110 272.6	112.3
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	18 693.2	101 987.9	18 090.3	108 470.3	106.4
Ундааны үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	59 998.7	340 419.6	50 468.3	328 530.3	96.5
Тамхины үйлдвэрлэл	2 018.6	10 293.0	5 762.4	13 465.1	130.8
Нэхмэлийн үйлдвэрлэл	95 320.3	432 934.8	51 336.7	211 642.2	48.9
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	3 040.0	17 346.2	3 384.1	11 592.2	66.8
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	1 647.2	10 624.8	2 446.2	12 744.2	119.9
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	858.4	6 214.0	979.2	6 454.0	103.9
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 430.9	15 622.2	4 274.4	20 678.4	132.4
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	4 330.3	20 483.8	7 390.3	24 432.3	119.3
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	40 019.3	190 165.5	33 558.0	166 297.5	87.4
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10 715.3	76 688.7	11 441.1	65 552.3	85.5
Резин болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 919.2	14 301.4	2 242.0	11 950.1	83.6
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	31 676.0	103 787.5	31 659.7	89 890.5	86.6
Төмрийн үйлдвэрлэл	20 132.1	115 193.3	20 932.1	113 478.5	98.5
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	1 638.3	3 719.0	451.4	1 889.3	50.8
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	66.0	841.1	11.0	19.4	2.3
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	56.8	245.2	4.7	892.0	3.6 <sup>1</sup>
Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэл	115.9	168.5	18.4	425.4	2.5 <sup>1</sup>
Автомашин, чиргүүл үйлдвэрлэл	-	-	254.2	370.7	-
Тээврийн бусад хэрэгсэл	270.0	1 678.1	331.5	1 981.1	118.1
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	1 561.6	8 144.1	773.0	4 495.5	55.2


<sup>1</sup> Дахин их

## 2.МАЛ АЖ АХУЙ



Улсын хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 31.0 сая хээлтэгч малын 23.7 сая (76.5%) нь 2020 оны эхний хагас жилд төллөсөн байна. Эм хонины 80.8 хувь, эм ямааны 74.2 хувь, үнээний 71.2 хувь, гүүний 63.3 хувь, ингэний 47.4 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 95.8 хувь буюу 22.8 сая төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 44.9 (0.2%) мянгаар буурсан байна.

*Төл бойжилт, төрлөөр, хувиар, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар*



Том малын зүй бус хорогдол 2020 оны эхний хагас жилд улсын хэмжээнд 1.3 сая болж, өмнөх оны мөн үеэс 573.7 (78.0%) мянгаар нэмэгдсэн байна. Харин 2020 оны 6 дугаар сард 95.1 мянган толгой мал хорогдсон нь өмнөх сараас 195.5 (3.1 дахин) мянгаар буурсан байна.

Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, хонь 658.0 мянга, ямаа 488.0 мянга, үхэр 94.7 мянга, адуу 67.5 мянган толгой, тэмээ 709 толгой хорогдсон байна. Нийт хорогдсон малын 50.3 хувийг хонь, 37.3 хувийг ямаа эзэлж байна.

## Зүй бусаар хорогдсон том мал, малын төрлөөр, жил бүрийн эхний хагас жилд

Малын төрөл	Хорогдсон том мал						Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь					
	2019			2020			2019			2020		
	V	VI	I-VI	V	VI	I-VI	V	VI	I-VI	V	VI	I-VI
	мянган толгой						хувь					
<b>Бүгд</b>	<b>184.7</b>	<b>109.0</b>	<b>735.1</b>	<b>290.6</b>	<b>95.1</b>	<b>1 308.8</b>	<b>0.28</b>	<b>0.16</b>	<b>1.11</b>	<b>0.41</b>	<b>0.13</b>	<b>1.84</b>
Адуу	10.2	6.9	38.2	24.4	6.3	67.5	0.26	0.17	0.97	0.58	0.15	1.60
Үхэр	9.3	5.8	49.1	24.4	7.3	94.7	0.21	0.13	1.12	0.51	0.15	1.99
Тэмээ	0.4	0.2	1.0	0.3	0.1	0.7	0.08	0.04	0.21	0.06	0.03	0.15
Хонь	78.8	47.3	308.5	137.3	40.4	658.0	0.26	0.15	1.01	0.43	0.13	2.04
Ямаа	86.0	48.8	338.3	104.2	41.0	488.0	0.32	0.18	1.25	0.36	0.14	1.67

Хорогдлыг аймгаар нь авч үзэхэд 2020 оны эхний хагас жилд Өвөрхангай аймагт 124.3 (9.5%) мянга, Булган аймагт 133.3 (10.2%) мянга, Хөвсгөл аймагт 267.1 (20.4%) мянга, Архангай аймагт 341.8 (26.1%) мянган толгой мал хорогдсон нь нийт хорогдлын 66.2 хувийг эзэлж байна.

Улсын хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон 31.0 сая эх малын 309.4 мянга (1.0%) нь 2020 оны эхний хагас жилд хорогдсон байна. Төв, Хөвсгөл, Архангай аймгуудад хээлтэгч мал 41.0-92.9 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 56.5 хувийг эзэлж байна. Харин 33.3 мянган толгой хээлтүүлэгч мал хорогдсоны 14.8 мянган ухна, 14.7 мянган хуц, 2.7 мянган бух, 1.1 мянган азарга, 18 толгой ат байна.

Улсын хэмжээнд 2020 оны эхний хагас жилд 35.9 мянган мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.4 (1.2%) мянгаар буурсан байна. Харин энэ оны 6 дугаар сард 1.0 мянган мал өвчнөөр хорогдсон нь өмнөх сараас 12.3 (13.1 дахин) мянгаар буурсан байна.

Хорогдсон нийт том малын 2.7 хувь нь өвчнөөр, 8.1 хувь нь аюулт үзэгдлээр, 89.1 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асганаас унах, өлдөх, даарах зэрэг шалтгааны улмаас хорогдсон байна.

## 3.ГАЗАР ТАРИАЛАН



Улсын хэмжээнд 2020 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар 536.8 мянган га талбайд тариалалт хийснээс үр тариа 390.1 мянган га-д, техникийн ургамал 63.8 мянган га-д, таримал тэжээл 53.9 мянган га-д, төмс 18.4 мянган га-д, хүнсний ногоо 9.6 мянган га-д, бусад ургамал 1.1 мянган га-д тариалсан байна.

Тариалсан талбай, ургамлын төрлөөр,  
жил бүрийн 7 дугаар сарын 1-ний байдлаар

	2017 VII.1	2018 VII.1	2019 VII.1	2020 VII.1	<u>2020 VII.1</u> <u>2019 VII.1</u>
	га				хувь
Бүгд	523 238.5	500 374.2	518 841.3	536 816.6	103.5 ↑
Үр тариа	390 843.9	367 194.5	369 251.9	390 082.8	105.6 ↑
Буудай	365 658.6	342 704.5	342 968.1	364 528.0	106.3 ↑
Төмс	14 952.8	12 727.0	14 808.6	18 436.3	124.5 ↑
Хүнсний ногоо	8 161.7	8 477.6	8 290.3	9 559.2	115.3 ↑
Таримал тэжээл	25 566.4	40 915.7	41 178.5	53 863.1	130.8 ↑
Техникийн ургамал	81 004.0	69 971.9	85 052.7	63 782.9	75.0 ↓
Бусад	2 709.8	1 087.4	259.3	1 092.2	4.2 <sup>1</sup> ↑

<sup>1</sup> Дахин их

Нийт тариалсан талбай өмнөх оны мөн үеэс 18.0 (3.5%) мянган га-гаар өссөн байна. Ургамлын төрлөөр авч үзвэл, үр тариа 20.8 (5.6%) мянган га, таримал тэжээл 12.7 (30.8%) мянган га, төмс 3.6 (24.5%) мянган га, хүнсний ногоо 1.3 (15.3%) мянган га, бусад ургамал 0.8 (4.2 дахин) мянган га-гаар нэмэгдэж, харин техникийн ургамал 21.3 (25.0%) мянган га-гаар буурсан байна.